

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/эхний 8-р сарын байдлаар/

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 6.9 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 41.4 хувиар биелсэн байна.

Баруун-Уртаас бусад бүх сумдын төсвийн орлогын төлөвлөгөө нь 4.1-60.5 хувиар давж биеллээ.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 5.1 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 1.2 тэрбум төгрөгөөр хэтэрчээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 42.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оны жилийн эцсээс 7.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 21.9 тэрбум төгрөг болсон нь 2011 оны жилийн эцсээс 5.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Ургац хураалт, хадлан бэлтгэл: 8-р сарын байдлаар аймгийн хэмжээнд Мөнххаан, Сүхбаатар, Уулбаян, Баруун-Урт сумд нийт 25.9 тн төмс, Асгат, Мөнххаан, Сүхбаатар, Уулбаян, Баруун-Урт сумд нийт 23.9 тн хүнсний ногоо, Баруун-Урт сум 1.5 тн тэжээлийн ургамал тус тус хураан аваад байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажил сумдад эхлэж байна. Баяндэлгэр, Онгон, Түвшинширээ, Уулбаян, Эрдэнэцагаан сумдаас бусад 8 сум нийтдээ 3.1 мянган тонн өвс, 0.1 мянган тонн гар тэжээлийг бэлтгэсэн гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 20.5 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 2.8 тэрбум төгрөгөөр дээгүүр, оны үнээр 79.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 10.2 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, ул боов, зайрмаг, нүүрс, цайрын баяжмал, замын хавтан, блокны үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 8-р сард өмнөх 2011 оны жилийн эцсийнхээс 5.7 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана мах махан бүтээгдэхүүн 50.0 хувиар, жимс, жимсгэнэ 23.4 хувиар, хүнсний ногоо 19.8 хувиар өссөн байна.

Боловсролын үйлчилгээний үнэ, тариф жилийн эцэст байсан хэмжээндээ тогтвортой байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 8 сард 866 эх амаржиж, 875 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 448 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 59-аар олон байгаа бөгөөд вируст гепатит, цусан суулга, тэмбүү, трихоминиаз, гахай хавдар, салхинцэцэг зэрэг өвчлөлүүд өссөн байна.


VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 810 болж урьд оны мөн үеэс 165 хүнээр хасагдсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 71.6 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 22 хувь нь дээд, 2.7 хувь нь тусгай дунд, 40.9 хувь нь бүрэн дунд, 7.3 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 8 сард 981 хүн шинээр бүртгүүлж, 839 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 488 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: : Эхний 8 сард 160 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 14-өөр дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 31 хүн нас барж, 49 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 152.3 сая төгрөгийн хохирол учирсны 150.5 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 127 хүн холбогдон сэжиглэгдсэний 33.8 хувь нь согтуугаар, 10.2 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 2040 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 187 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 83 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС